



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/234

Мөрөн сум

Дипломат, гадаад албан паспорт
олгох хүсэлт уламжлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам"-ын 2.2.2, 3.7.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цагаан-Уул сумын Засаг дарга С.Гончигням, Тамгын газрын дарга Т.Мөнхбаяр нар 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдрөөс 14-ний өдрийн хооронд Бүгд Найрамдах Солонгос Улсын Тэжон хотын Со дүүрэгт болох "Аялал жуулчлалыг хэрхэн хөгжүүлэх вэ?" семинарт оролцох болсонтой холбогдуулан албан паспорт олгуулах хүсэлтийг Гадаад харилцааны яаманд уламжилсугай.

2. Гадаад улсад албан томилолтоор ажилласан тухай бүртээ холбогдох мэдээллийг илтгэх хуудсаар аймгийн Засаг даргад танилцуулж ажиллахыг Цагаан-Уул сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Т.Мөнхбаяр), Цагаан-Уул сумын засаг дарга (С.Гончигням) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (П.Ариунбат)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН